



**ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**2020 оны 03 дугаар сарын 04**

**ХУРЛЫН ЗААЛНЫ АУДИО СИСТЕМ /ДҮРСТ ХУРЛЫН СИСТЕМД ШААРДАГДАХ  
ПРОГРАМ ХАНГАМЖ БОЛОВСРУУЛАХ/ НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: *Хурлын заалны аудио систем /Дүрст хурлын системд шаардагдах  
програм хангамж боловсруулан, нийлүүлэх/*

Харьцуулалт/  
Гэрээний дугаар: **ЭХЗХ/202002007**

**Улаанбаатар хот  
2020 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**“Эрчим хүчний зохицуулах хороо”** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Хурлын заалны аудио систем /Дүрст хурлын системд шаардагдах програм хангамж боловсруулан, нийлүүлэх/ тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул **www.tender.gov.mn** хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 20000 (хорин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг **2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 11:00** цагаас өмнө системд ирүүлэх.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 11:30**-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх: **Эрхгүй.**

Дотоодын давуу эрх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол улс, Улаанбаатар хот, Их сургуулийн гудамж 2а,**

**Эрчим хүчний зохицуулах хороо, 1 давхар 101 тоот,**

**ЗУГ-н мэргэжилтэн Б.Батбаяр**

**Утас: 99074011**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бусад**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан
- 6. Үнийн саналын хүчинтэй байх**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл /2019 онд гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт/</li> <li>2. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо 1 /2019 он аудитын дүгнэлтийн хамт Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>3. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</li> <li>4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</li> <li>5. Харилцагч бүх банкны тодорхойлолт;</li> <li>6. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын <a href="http://www.etax.mta.mn">www.etax.mta.mn</a> сайтаас авч ирүүлэх.</li> <li>7. Бараа нийлүүлэлтийн хуваарь. /Маягтын дагуу/</li> <li>8. Бараа нийлүүлэлтийн үнийн хуваарь. /Маягтын дагуу/</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Огноо: <b>2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр 11:00 цаг.</b></p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: <b>Монгол улс, Улаанбаатар хот, Их сургуулийн гудамж 2а, Эрчим хүчний зохицуулах хорооны байр,</b> Давхар болон өрөөний дугаар: <b>4 дүгээр давхар, Хурлын танхимд нээнэ.</b> Огноо: <b>2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр</b> Цаг: <b>11:30 цаг</b></p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгууллагын албан хүсэлт</li> <li>2. Байгууллагын танилцуулга</li> </ol>
ТӨӨЗ 6.1	<p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт (Adobe PDF) шилжүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: <b>Хурлын заалны аудио систем /Дүрст хурлын системд шаардагдах програм хангамж боловсруулан, нийлүүлэх/ ЭХЗХ/202002007</b></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### Хорооны хурал

Эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хороо нь шийдвэрлэх асуудлаа Хорооны хурлаар хэлэлцдэг бөгөөд хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байдаг. Хорооноос батлан гаргасан хурлын журамд ээлжит хурлыг сард 1-ээс доошгүй удаа зохион байгуулна гэж заасан бөгөөд 7 хоног бүрийн мягмар гарагт урьдчилсан хэлэлцүүлгийг, пүрэв гарагт хорооны хурлыг зохион байгуулдаг. Хурлаар тусгай зөвшөөрөл олгох, түүний нөхцөл, шаардлагыг тогтоох, тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хянаж дүгнэх, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын болоод хэрэглэгчийн үнэ тарифыг батлах, эрчим хүчний хэмнэлттэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, салбарын хэмжээнд болоод дотооддоо мөрдөгдөх дүрэм, журам, заавар, аргачлал боловсруулах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг болно. Хурал нь танилцуулга, асуулт хариулт, санал дүгнэлт, шийдвэр гаргах гэсэн үндсэн 4 хэсгээс бүрдэх бөгөөд хэсэг тус бүрийн үргэлжлэх хугацааг дэгээр зохицуулдаг. Эрчим хүчний зохицуулах хороо нь Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн нийт 190 гаруй тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын асуудлыг хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг.

### Зорилго

Харилцаа холбооны технологийг ашиглан дуу болон дүрс хэлбэрээр хоёр ба түүнээс дээш байршлын хооронд мэдээлэл дамжуулах, Улаанбаатар хот болон 21 аймагт орших тусгай зөвшөөрөл эзэмшигч компанитай дүрст хурал зөвлөлгөөнийг нэгэн цагт зохион байгуулах боломжтой болгоход оршино.

### Онлайн хурал

- Нэмэлт програм ашиглалгүй браузероор холбогдох
- Веб-д суурилсан програм хангамж байх
- Эх код манай эзэмшилд шилжих
- Хугацааны хязгааргүйгээр хуралдах
- Холбогдох харилцагчийн хязгааргүй
- Нууц үгтэй хурлын өрөө үүсгэх
- Дэлгэц хуваалцах
- Зөвхөн сонгогдсон хэрэглэгч холбогдох
- Дүрст хурлыг зохион байгуулах шийдэл ирүүлэх
  
- Хуралд оролцох байгууллагын бүртгэл
  - Хурлын цахим систем дээр хурлын зарыг цаг минутаар товлох
  - Товлосон цаг болох үед мэдэгдэх
  - Зөвхөн товлосон цагт онлайн хуралд оролцох боломжтой байх
- Онлайн видео хурал зохион байгуулах
  - Хурлыг зарласан цагаар ээлжлэн байгууллагуудыг оролцуулах
  - Хурлын танилцуулга, заал, оролцогч, удирдагч, зохицуулагч нар нэгэн зэрэг холбогдох
  - Хурлын үеээр ярьж буй даргыг томоор хуралд оролцогчид харуулах
  - Хуралд оролцогч нар өөр өөрийн камертай байх ярих үеээр томрон дэлгэцэнд харагдах
  - Заалны шуум болон нөгөө талын дуу, дүрс тасалдахгүй байх

### Шаардагдах тоног төхөөрөмж

- Сервер компьютер
- Өндөр хурдны өргөн өнцөгийн утасгүй камер /8mb-с дээш/
- Микрофон
- Яригч

**Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмж и х нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[тоо]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| <b>1. Шалгах болон турших</b>                            | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэл</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                               | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг</b>            | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын</b>                             | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>1</b> жил байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт</b>                               | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>   | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>3</b> хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                        | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                             | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг</b>               | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                          | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |



## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Эрчим хүчний зохицуулах хорооны серверт суурилуулна. Програм хангамжийг туршин нэвтрүүлэх, тестлэх ажлыг зохион байгуулж, хэрэглэгчийн хандалтыг тодорхойлон ачааллыг тооцож, шаардлагатай тохируулга хийсэн байна.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"><li>1) Эрчим хүчний зохицуулах хорооны хурлын заалны аудио систем /Дүрст хурлын системд шаардагдах програм хангамж, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) Програм хангамж суурилуулсан ажлын акт, холбогдох баримт бичиг</li><li>3) Баталгаат засварыг 1 жилийн хугацаанд үзүүлнэ гэсэн байгууллагын албан бичиг</li><li>4) Програм хангамжийн эх кодыг агуулсан CD, DVD;</li></ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. 1 жил байна.   |
| <b>4. Төлбөр</b>  | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн <b>50</b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН -</b>                                 | <p>9.1. Алданги оногдуулах хувь: <b>0,1</b></p> <p>Алдангийн нийт дүн: <b>1 хувь</b></p>   |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга,  
тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын  
үсэг)

\_\_\_\_\_  
(Албан  
тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан  
тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож  
\_ оны \_ сарын \_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр,  
\_ төгрөгийн орон нутгийн төсвийн \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр, \_ хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн  
барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал,  
нэр] [Гарын үсэг]*

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын  
дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны  
дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал,  
нэр] [Гарын үсэг]*

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын  
дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*